

БУЛГАН СУМЫН ИТХ-ЫН 7 ДАХЬ УДААГИЙН СОНГУУЛИЙН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД БАРИМТЛАН АЖИЛЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Булган сумын ИТХ-ын эрхэм зорилго нь: Монгол Улсын үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон, бусад хууль тогтоомжид заагдсан бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэн иргэдийн язгуур эрх ашгийг хамгаалж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, НӨУБ-ын үйл ажиллагааг бэхжүүлэхэд багийн ИНХ, иргэдийн идэвх оролцоог ханган ажиллахад оршино.

Булган сумын ИТХ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь дараах 4 бүлэг арга хэмжээний хүрээнд ажиллана.

Нэг: Нийгмийн хөгжлийн асуудал

Хоёр. Эдийн засгийн хөгжлийн асуудал

Гурав: НӨУБ-ын зохион байгуулалт, хяналт шалгалт, орон нутгийн өмчийн асуудал

Дөрөв: Иргэдийн идэвх оролцоог дэмжих, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал

НЭГ. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ

1.1 Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газар, дээд шатын байгууллагуудын баталсан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулсан Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэн дүгнэлт өгөх.

1.2 Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар тодорхойлсон шийдвэр гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих, энэ арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэний хамтын оролцоог хангаж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах.

1.3 Сургуулийн өмнөх болон, бага дунд боловсролын байгууллагуудын талаар, мөн боловсролын байгууллагуудтай холбоотой үндэсний болон, дэд хөтөлбөрүүдийн талаар сумын Засаг даргын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, чиглэл өгөх, орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг /Спортын дунд сургууль/ хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэнд хяналт тавих.

1.4 Соёл, спортын талаар 2016-2020 онд сумын Засаг даргын дэвшүүлсэн зорилтын биелэлтийг дүгнэж, энэ талаар хэрэгжүүлж буй төрийн бодлого болон, соёл, биеийн тамирын хууль тогтоомжийн дагуу хөгжүүлэх, иргэдийн соёл, биеийн тамирын эрэлт хэрэгцээг хангах, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалахад хяналт тавих.

1.5 “Ахмадуудын эрүүл мэнд, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг тооцох, цаашид авах арга хэмжээний талаар ИТХ-ын болон, тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэх.

1.6 Гэр бүл, Эмэгтэйчүүд, Хүүхэд, Залуучууд, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэдэнд үзүүлэх нийгмийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэхэд бодлогын түвшинд анхаарч ажиллах.

1.7 Нийгмийн салбарын байгууллагуудын удирдах болон, гүйцэтгэх ажилтан албан хаагчдын мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх, ажиллах орчин нөхцөлийг бэхжүүлэхэд анхаарах.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ

2.1 Аймаг, сумын хөгжлийн дунд, урт хугацааны төрөлжсөн болон бүсчилсэн хөтөлбөр, стратегийн баримт бичгүүдийн үзэл баримтлалтай ойрын жилүүдийн хөгжлийн бодлого, зорилтуудыг уялдуулах, хэрэгжилтийг хангуулах.

2.2 Сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт болон сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тухайн жилийн зорилт бүрийн хэрэгжилттэй хагас жил тутам танилцаж, жил бүрийн эцэст дүгнэлт хийж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч ажиллах.

2.3 Сумын төсөв, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлж, орон нутгийн хөгжлийг эдийн засгийн үр ашгийн тооцоогоор тодорхойлж ОНХС /Орон нутгийн хөгжлийн сан/, Сум хөгжүүлэх сангийн төслийн боловсруулалт хувиарлалтыг тооцох, түүний үндэслэлийг сайжруулах арга хэмжээ авах, дотоод аудитын тогтолцоог сайжруулж ил тод байдлыг хангуулахад хяналт тавьж ажиллах.

2.4 Сум, орон нутгийн өргөн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүн, газар тариалан, жимс жимсгэнэ, эрчимжсэн мал аж ахуй, малын гаралтай түүхий эд боловсруулах, барилга, барилгын материал үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрүүдийн хөгжлийг дэмжих бодлого баримтлах.

2.5 Сумын дэд бүтэц, зам талбай, газрын зохион байгуулалтын зохистой төлөвлөлт, барилга байгууламж, ногоон байгууламжийн талаар нэгдсэн бодлого баримтлан хөрөнгө оруулалт хуваарилахад дэмжлэг үзүүлэн ажиллах.

2.6 Сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлаар тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан жил бүрийн зорилтуудыг нэгтгэн томъёолсон “Онцгой” зорилт дэвшүүлэх, түүнд зориулагдсан ажлын хэсгийг байгуулж, уг асуудлаар тусгайлсан удирдамж боловсруулах, удирдлага зохицуулалтын арга хэмжээг авах.

ГУРАВ. НӨУБ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АСУУДАЛ

3.1 Сумын ИТХ, түүний бүтэц, нэгжүүдийн үйл ажиллагааны журам, хуваарь, ИТХ-ын албаны ажлын байрны тодорхойлолт, чиг үүрэгт тавигдах шалгуур, шаардлага, хариуцлагыг шинэ бодлого, зорилтод уялдуулан шинэчлэх.

3.2 Хурлын хуралдаан болон тэргүүлэгчдийн хурал, хороодын ажлыг олон нийтэд нээлттэй ил тод болгох, тухайн хэлэлцэж буй асуудлаар нь холбогдох мэргэжлийн байгууллага, иргэдийн төлөөллийг татан оролцуулах, үйл ажиллагааны мэдээллээ нийтэд хүртээмжтэй хүргэж байх.

3.3 Багийн Иргэдийн Нийтийн хурлуудыг ЗЗНДНТУТХууль, сумын дүрмийн хүрээнд ажиллаж, үйл ажиллагааны үр дүнгээ тооцон, зорилтоо богино, дунд, урт хугацаагаар төлөвлөн хэрэгжүүлдэг бие даасан байгууллага болгон төлөвшүүлэх.

3.4 Төлөөлөгчид тухайн тойрогтоо төлөөлөгчийн нэрэмжит, сумын хэмжээнд ИТХ-ын нэрэмжит нэгдсэн үйл ажиллагааг жил бүр зохион байгуулах, хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулах, цаг үеийн шаардлагатай асуудлаар тэргүүлэгчид болон хороодоос эрхэлсэн ажлынхаа хүрээнд хяналт шалгалт, судалгаа шинжилгээг хийж, зохистой шийдлийн төсөл боловсруулж шийдвэрлүүлэх, нийтийн анхааралд орсон асуудлаар тавьсан асуулгын мөрөөр ажиллаж дүнг танилцуулах, хурал, тэргүүлэгчдээс гарсан шийдвэр, баталсан хөтөлбөр, зорилт бүрийнхээ хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцох, зохион байгуулсан ажлаа тайлагнан сурталчилах зэрэг НӨУБ /Нутгийн Өөрөө Удирдах Байгууллага/-ын байнгын үйл ажиллагаа, хүлээсэн хариуцлага, сонгогчдын итгэл найдварыг биелүүлэхтэй холбоотой манлайллыг хангахад ахиц гаргах.

3.5 Сумын ИТХ-ын төлөөлөгчдийг мэдээллээр хангах, зорилтот болон захиалгат сургалтанд хамруулах, ажлын албаны ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургах сургалтуудад эрэлт хэрэгцээ, ажлын шаардлагыг нь харгалзан хамруулах, багийн ИНХ-д мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, ажилд нь хяналт шалгалт хийх, үнэлгээ дүгнэлт өгөх, төлөөлөгчид, багийн хурлыг шаардлагатай ном сэтгүүл, гарын авлага, арга зүйн мэдээллээр хангах, туршлага судлуулах, арга барилыг нь харилцан танилцуулах зэрэг ажил мэргэжлийн болон бусад соёл, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах.

3.6 Нутгийн өөрөө удирдах байгууллага ИТХ-ын нэгдсэн цахим хаяг /ХУРАЛ.МН/, Булган сумын вэб хуудас болон, ИТХ-ын албан ёсны нүүр хуудас /Булган аймгийн Булган сумын ИТХ/-аар дамжуулан сумын ИТХ-ын үйл ажиллагааг нийтэд ил тод мэдээлэх, ард иргэдээс санал зөвлөмж хүлээн авах.

3.7 Сумын ИТХ, ЗДТГазраас гадаад улс болон бусад аймаг, сум, багийн ижил төрлийн үйл ажиллагаатай байгууллагатай албан харилцааг тогтоох, туршлага судлах ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах.

3.8 Сумын ИТХ-ын хороодоос тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын график төлөвлөгөөг гаргуулан баталж, хороодын үйл ажиллагааг дэмжих.

3.9 НӨУБ-ын үйл ажиллагааг өсвөр насны хүүхэд залуучууд, ЕБС суралцагчдад таниулах үүднээс “МИНИ ИТХ”-ыг байгуулан, ИТХ-ын тодорхой ажлуудад оролцуулах, тэдэнд төлөөллийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг сурталчилах.

3.10 Өмнөх ИТХ-уудын үед баталсан, одоо мөрдөгдөж байгаа дүрэм журмуудын хэрэгжилтийг тооцож, дүн шинжилгээ хийх, шинэчлэн боловсруулах шаардлагатайг нь ээлжит болон, ээлжит бус хуралдаан, тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн баталж хэрэгжилтийг хангуулах.

3.11 2017 оныг “Орон нутгийн өмчийг тоолох жил” болгож, жилийн ажлын хүрээнд Булган суманд харьяалагдах өмчийн бүх төрлийн байгууллагуудад үзлэг тооллого явуулах ажлын хэсгийг байгуулж, тайланг хэлэлцүүлэх.

3.12 Орон нутгийн өмчийг зүй зохистой ашиглах талаар журам боловсруулан хэрэгжилтийг жил бүр тооцон ажиллах.

3.13 Сумын өмч хамгаалах зөвлөлд бүртгэлгүй өмчийг эзэнжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлийг өгөх, тайланг 2017 оны эцэст ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэх.

**ДӨРӨВ. ИРГЭДИЙН ИДЭВХ ОРОЛЦООГ ДЭМЖИХ,
ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ**

4.1 Сумын ИТХ, БИНХ-ууд, ЗДТГ-ын дэргэд ажиллаж байгаа Иргэний танхимын үйл ажиллагааг идэвхижүүлэх, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл зэрэг зардал хөрөнгөтэй холбоотой бусад асуудлыг бүрэн эрхийн хугацаанд шийдвэрлэх.

4.2 Иргэдийн санал санаачлагыг идэвхжүүлэх, мэдээллээр хангах, сургалтууд зохион байгуулах, оролцооны байгууллагуудыг дэмжих, гаргасан шийдвэр, бодлого, зорилтоо иргэдэд шуурхай хүргэх, сурталчилах.

4.3 Аливаа асуудлаар шийдвэр гаргах, бодлого хэрэгжүүлэхийн өмнө тухайн асуудалтай холбогдох хувийн хэвшлийн ААН-үүд, төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийн дунд хэлэлцүүлэг явуулах, саналыг нь судлах, гарсан саналыг бодлого, шийдвэрт тусгах, үр дүнг эргэн мэдээлэх тогтолцоог сумын ИТХ-ын ажлын алба, төлөөлөгч нарын ажлын үндсэн арга хэлбэр, хэм хэмжээ болгох.

4.4 Байгаль орчноо хамгаалах, бохирдлоос сэргийлэх, ахмад үеэ хүндэтгэх, түүхийн болон, ёс заншил, өв соёлын хүмүүжлийг хүүхэд залууст өвлүүлэн дэлгэрүүлэх ажлыг боловсрол, соёл, эрүүл мэнд, байгаль орчны салбарын байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

4.5 Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр баталсан дүрэм журмуудын хэрэгжилтийг тооцон ажиллах.

4.6 Иргэдийн эрх, эрх чөлөөг хангах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд байгууллага, иргэдийг хамруулж, тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр гэмт хэрэг, зөрчлийг бууруулах ажлын төлөвлөгөөг жил бүрийн 1-р улиралд батлан зохион байгуулах.

4.7 Сумын хэмжээнд нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, авилгатай тэмцэх, малын болон орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ